

213



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АКТ
Дугаар 04

2018 оны 01 сарын 04 өдөр

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын хэлтэст ажлаасаа гарсан ажилтанд 2017 оны 7 дугаар сард 700000 төгрөгийн цалин мэдээлж, даатгуулагчаас болон ажил олгогчоос төлөх шимтгэл болох 147000 төгрөгийг төлсөн байна.

Энэ нь нийгмийн даатгалын тухай хуулийн шимтгэл төлөх журмын 16.2-т заасан “шимтгэлийн тайлан буюу ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэл тодорхойлох хуудсыг үндэслэн шимтгэлийн тооцоог хийх”, мөн 17.1.1-д “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Нийгмийн даатгалын хэлтэст илүү төлөгдсөн шимтгэл болох 147000 / нэг зуун дөчин долоон мянган/ төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж Баянхонгор аймгийн

2517035

Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны дотор Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэхийг Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Хашбилэг, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР



Б.НАРАНГЭРЭЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН

ЗАХИРАЛ



Ө.ХАШБИЛЭГ

НЯГТЛАН БОДОГЧ



Б.МӨНХТОГТОХ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АКТ
Дугаар 05

2018 оны 01 сарын 04 өдөр

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тэтгэвэр тогтоолгосон ажилтан Х.Сарантуяагийн цалингийн ажил олгогчоос болон даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 16.6%-иар тооцохыг 21%-иар тооцож ажил олгогчоос 138194 /нэг зуун гучин найман мянга нэг зуун ерэн дөрвөн / төгрөг, даатгуулагчаас 138194 /нэг зуун гучин найман мянга нэг зуун ерэн дөрвөн төгрөг/-ийг нийгмийн даатгалын хэлтэст илүү төлсөн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1-д "заасан дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө" гэсэн заалтыг зөрчжээ.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т " аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан"...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Нийгмийн даатгалын хэлтэст ажил олгогчоос илүү төлөгдсөн 138194 /нэг зуун гучин найман мянга нэг зуун ерэн дөрвөн/ төгрөгийг нийгмийн даатгалын хэлтэсээс суутган тооцож төлбөрийг барагдуулах

2517037

2. Мөн Х.Сарантуяагийн цалингаас илүү суутгасан шимтгэл болох 138194 /нэг зуун гучин найман мянга нэг зуун ерэн дөрвөн / төгрөгийг буцаан олгох.

3. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 1 дүгээр сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэхийг Галуут сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Цэгмид, нягтлан бодогч С.Ариунжаргал нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

ЗӨВШӨӨРСӨН

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР


ГАЛУУТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ

Б.НАРАНГЭРЭЛ

С.ЦЭГМИД

НЯГТЛАН БОДОГЧ

С.АРИУНЖАРГАЛ



207



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2018 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 20

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн тооцооллыг давтан шалгахад 2017 оны 10 дугаар сарын цалингаас нэр бүхий 4 ажилтны ХХОАТ-ыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17.1.1-д заасан “энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр ногдуулна”, 26.1.2-д “энэ хуулийн ...11.1.1-д заасан албан татварыг сар бүрийн эцэст ногдуулж төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 д “Улс болон орон нутгийн төсөв...орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” зөрчилд Төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилчдаас суутгаагүй ХХОАТ-ын 189700 /нэг зуун наян есөн мянган долоон зуун/ төгрөгийг холбогдох хүмүүсээс суутган төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2517067

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын төвийн дарга Э.Цэнд, нягтлан бодогч Т.Одонтуяа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТОР



Б.НАРАНГЭРЭЛ

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН ДАРГА



Э.ЦЭНД

НЯГТЛАН БОДОГЧ

Т.ОДОНТУЯА

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 21

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг нэр бүхий 13 ажилтныг шагнаж, тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-г “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 800641 /найман зуун мянга зургаан зуун дөчин нэгэн/ төгрөгийг төрийн сан дахь бусад татварын хураамжийн орлогын 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг

2517009

Зоонозын өвчин судлалын төвийн дарга Э.Цэнд, нягтлан бодогч Т.Одонтуяа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

АУДИТОР



Б.НАРАНГЭРЭЛ


ЗӨВШӨӨРСӨН:

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН

ТӨВИЙН ДАРГА

 Э.ЦЭНД

НЯГТЛАН БОДОГЧ

 Т.ОДОНТУЯА

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.